



ДУНДГОВЬ АЙМАГ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 11/21

Хараат

Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Тус сумын Замын улаан багийн нутаг “Ланс” гэдэг газарт хаваржиж байгаа малчин М.Мөнхтогтохын суурьт малын гоц халдварт бол малын Мялзан өвчин оношлогдож хорио цээрийн дэглэмийн хугацаанд сүүлчийн мал эдгэрснээс хойш 21 хоногийн хугацаанд нэмэж мал өвчлөөгүй тул 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2. Хязгаарлалтын бүсэд байгаа малд үзлэг тандалт, ариутгал халдвартайжүүлэлтийн ажлыг зохион байгуулахыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч (Ж.Чулуунбат)-д үүрэг болгосугай.

3. Малчид иргэд олон нийтэд малын гоц халдварт бол малын Мялзан өвчинөөс урьдчилан сэргийлэх, гарын авлаг, мэдээ мэдээллийг цахимаар олон нийтэд хүргэх, голомт сэжигтэй бүс нутгийн малчдад малын хариуллага маллагаатай байлгаж, хязгаарлалтын дэглэмийн журмыг мөрдөж ажиллах талаар мэдээл өгөхийг МЭТасгийн дарга Т.Өлзийбат, БЗДарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА А.ЭРДЭНЭСАЙХАН